



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2021 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 38

Мандалговь

Монгол Улсын цол хүртээх, одон,
медалиар шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь :

1. Дундговь аймаг дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн нярав Ширчин овогтой Нармандах, Сайнцагаан сумын 5 дугаар багийн иргэн хувиараа хөдөлмөр эрхлэгч Лут овогтой Бээжинхүү нарыг “Алтан гадас” одонгоор, Дундговь аймаг дахь ХААН банкны салбарын борлуулалт үйлчилгээний ажилтан Жанлав овогтой Ууганбаярыг “Хөдөлмөрийн хүндэт” медалиар шагнуулахаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд уламжилсугай.

2. Шагналын материалыг холбогдох хууль, журам, зааврын дагуу бүрдүүлж, дээд шатны байгууллагад хүргүүлэхийг Засаг дарга (С.Бат-Оргил)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Т.БАТЖАРГАЛ